

БАТЛАВ:
БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД

.....
Б.МОНХБААТАР

БАТЛАВ:
МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

.....
Ц.НЯМДОРЖ

БАТЛАВ:
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

.....
Х.НЯМБААТАР

ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН ДЭД БҮТЦИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 3.6-д “Ухаалаг, иргэн төвтэй газрын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх замаар тэгш байдал, шударга ёс, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангана.” гэсэн зорилтыг дэвшүүлж, 2031-2040 онд үндэсний орон зайн мэдээллийн нэгдсэн платформыг бий болгон хөгжүүлж, хэрэглэж хэвшсэн байх үр дүнд хүрэхээр заасан бөгөөд “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 3.6.16, 5.3.7-д “Байрлалд суурилсан орон зайн мэдээллийн эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлнэ.”, “Орон зайн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлж шийдвэр гаргах бүх түвшинд ашиглана.” гэж тус тус тусгагдсан.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.7.2-т “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд олон улсын геодезийн сүлжээнд холбогдсон, байнгын ажиллагаатай станцуудаас бүрдсэн геодезийн хэмжил зүйн дэд бүтэц, хаягжилтын нэгдсэн системийг монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулж, тэдгээрийн тоон мэдээллийг түгээх тогтолцоог үе шаттайгаар бий болгоно гэж заасан.

1.2.Практик шаардлага:

Мэдээллийн технологийн салбар эрчимтэй хөгжиж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага орчин үеийн дэвшилтэт техник, технологи (ухаалаг гар утас, түүнтэй адилтгах төхөөрөмж зэрэг)-ийг ашиглан төрөл бүрийн контент гаргах, сургалт, судалгаа хийх, бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, хөгжүүлэх явдал түгээмэл байгаа өнөө үед байрлалд суурилсан орон зайн тоон өгөгдөл, мэдээллийн ач холбогдол нэмэгдэж, түүнд тулгуурласан нэгдсэн системийг байгуулан нийтийн болон албан хэрэглээнд нэвтрүүлэх зайлшгүй хэрэгцээ, шаардлага үүсч байна.

Улсын хэмжээний байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээлэл бүхий дэд бүтцийг бий болгон хөгжүүлснээр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын амьдрал, бизнесийн үйл ажиллагаанд таатай нөлөө үзүүлж, боломж, нөхцөлийг нэмэгдүүлэх төдийгүй төрийн бодлого, шийдвэрийг нэгдсэн байдлаар зөв зүйтэй төлөвлөх, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд томоохон түлхэц үзүүлэхээр байна.

Олон улсад орон зайн өгөгдөл, мэдээлэлд тулгуурлан улс орны бүтээн байгуулалт, дэд бүтцийг төлөвлөх, барьж байгуулах болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах зэрэг эдийн засаг, нийгмийн гол хүчин зүйлсийг урьдчилан тооцох, төлөвлөх үйл ажиллагаанд нэгдсэн платформоор дамжуулан ашигладаг байна.

Мөн байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээллийг статистикийн болон бусад бүх төрлийн тоон өгөгдөл, мэдээлэлтэй нэгтгэн анализ дүгнэлт хийж, төрийн үйлчилгээний болон бизнесийн шинэ санааг боловсруулан хэрэгжүүлэхэд ашиглан үр ашгийг нь хүртэж байгаа туршлага түгээмэл байна.

Орон зайн өгөгдлийн дэд бүтцийг 1990 оноос хойш 100 гаруй улсад байгуулан хэрэгжүүлж байгаа бөгөөд АНУ, Австрали болон Европын ихэнх улс орнууд үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үзэл баримтлалд тулгуурласан дэд бүтцийг байгуулах, хөгжүүлэх чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг үе шаттайгаар амжилттай хэрэгжүүлж байна. Гадаад улс, орнуудын хувьд төрийн болон олон нийтийн байгууллага, иргэдэд орон зайн өгөгдөл, мэдээллийг зохих эрхийн хүрээнд чөлөөтэй хайх, хандах, хэрэглэх боломжийг бүрдүүлсэн байдаг төдийгүй байрлалд суурилсан мэдээллийн хэрэглээний үр өгөөжийг хүртэж эхэлснийг нь өнөөгийн дэвшилтэт техник технологийг ашигласан, шинэлэг шийдэл бүхий тэсрэлт хийсэн бизнесийн загваруудыг хөгжүүлж байгаагаас тодорхой харагдаж байна.

Орон зайн өгөгдлийн дэд бүтэц гэдэг нь орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч, хэрэглэгч болон тэдгээрийн хамтын ажиллагааг удирдан зохион байгуулах үйл ажиллагаа, бодлого, хууль, эрх зүй, стандарт, техник, технологи, хүний нөөцийн цогцыг ойлгох бөгөөд байгууллагуудын чиг үүрэг, байрлалыг хамаарахгүйгээр нэг удаа бүрдүүлсэн мэдээллийг төрөл бүрийн үйл ажиллагаанд олон удаа ашиглах, шинэчлэх боломжийг бий болгоход оршиж байна.

Манай улсын хувьд хүчин төгөлдөр үйлчилж буй 13 хуульд орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, ашиглах, түгээхтэй холбогдсон асуудлыг зохицуулсан давхардсан тоогоор 44 мэдээллийн сангийн талаар зохицуулалт байгаа хэдий ч дээрх мэдээллийн сангуудыг уялдуулах, нэгтгэх, орон зайн өгөгдөл, мэдээллийн нэгдсэн системийг бий болгож, хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбогдсон эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Улсын хэмжээний байрлалд суурилсан орон зайн өгөгдлийг агуулсан мэдээллийн сангууд нь зөвхөн тухайн нэг салбар, байгууллагын хэрэгцээнд ашиглагдаж, албан бичиг болон цаасан хэлбэрээр мэдээллийг бүрдүүлэх, солилцох хэлбэрээр ашиглагдаж байгаа нь улсын эдийн засаг, нийгмийн бодлого, төлөвлөлт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээг үр дүнтэй, амжилттай хэрэгжүүлэхэд төдийлөн дэмжлэг болохгүй байна.

Төрийн захиргааны төв байгууллагуудаас авсан судалгааны үр дүнгээс харахад орон зайн өгөгдөл, мэдээллийг албан бичгээр болон цаасан хэлбэрээр солилцож, мэдээллийн санг хүснэгт, зурган мэдээлэл бүхий цаасан хэлбэрээр бүрдүүлж, бүрэн нэгтгээгүй, уялдаа холбоогүй хөтлөн явуулж байгаа нь мэдээлэл солилцох, түгээх, бүрдүүлэх, ашиглах үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна.

Орон зайн өгөгдөл, мэдээллийн нэгдсэн системгүй байгаагаас шалтгаалан салбар бүр өөр өөрийн гэсэн арга аргачлалаар орон зайн өгөгдлийг давхардуулан бүрдүүлж, хөрөнгө оруулалтын үргүй зардал гаргаж байгаа төдийгүй төрийн

бодлого, шийдвэр нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтгүй, уялдаагүй гарахад хүргэж байна.

Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн суурь өгөгдлийг нэгдсэн стандартын дагуу боловсруулж, бүрдүүлэхгүй байгаагаас цахим хэрэглээ, төрөл бүрийн хайлтын системд хэрэглэх, ашиглах, бизнесийн орчныг хөгжүүлэх нөхцөлийг хязгаарлаж байна.

Олон улсын туршлагаас үзэхэд янз бүрийн эх үүсвэрээс бүрдсэн орон зайн өгөгдөл, мэдээллийн өргөн хүрээг нэгтгэх замаар орон зайн бүтээгдэхүүн, үйлчилгээг гаргаж, орон зайн мэдээллийг хэрэглэх, ашиглах, түгээх, солилцох зэрэг үйл ажиллагаанд ашиглаж, оролцогч талуудын харилцааг лицензийн гэрээгээр зохицуулдаг байна. Лиценз нь орон зайн өгөгдөл, мэдээллийг хэрэглэгч болон түгээгчийн хооронд үүсэх ашиглах эрхийн (хуулбарлах, ашиглах, дахин нийтлэх, нэмүү өртөг шингээх гэх мэт) асуудал бөгөөд хуулийн төсөлд "хандах эрх" гэсэн нэр томъёогоор хэрэглэгдэж зохих журмаар зохицуулагдахаар тусгана.

Орон зайн өгөгдөл, мэдээллийг ашиглах, хандах эрхийн зохицуулалтыг бий болгосноор иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, бизнесийн ашигтай санаа, инновацыг хөгжүүлэх, дэмжихэд чухал нөлөө үзүүлж, хэрэглэгчид үйлчилгээг чирэгдэлгүй, хурдан шуурхай, чанартай үзүүлэх ач холбогдолтой байна.

Иймд байрлалд суурилсан орон зайн өгөгдлийн дэд бүтцийг хөгжүүлэх, орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх, хэрэглэх, үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, хяналт тавих болон орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч, хэрэглэгчийн үйл ажиллагаа, харилцааг зохицуулах, иргэдэд шуурхай, чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, улмаар төсвийн үргүй зардал, давхардсан хөрөнгө оруулалтыг арилгах зорилгоор орон зайн өгөгдлийн дэд бүтцийн эрх зүйн орчныг бий болгох зайлшгүй шаардлагатай байна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг дараахь агуулга бүхий 5 бүлэг, 21 зүйлтэй байхаар боловсруулна.

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, үйлчлэх хүрээг тодорхойлж, орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, түүнийг хэрэгжүүлэх арга, нэр томъёоны тодорхойлолтыг тусгана.

Хоёрдугаар бүлэгт орон зайн өгөгдлийн ангилал, төрөл, дүрслэл, мэдээлэл, тэдгээрийн бүрдлийг болон суурь орон зайн өгөгдлийн бүрэлдэхүүн мэдээллүүдийг өнөөгийн нөхцөл байдал, олон улсын түвшинтэй хэрхэн харьцуулан гаргах зохицуулалтыг тусгаж, орон зайн өгөгдлийн мета-дата бүрдлийн тухай болон хандах эрхийн төрлийн талаар тусгана.

Гуравдугаар бүлэгт орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааны зохицуулалт буюу өгөгдөл бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх, хэрэглэхтэй холбогдсон үйл ажиллагааг тусгаж, орон зайн өгөгдлийн дэд бүтцийн техникийн зохицуулалт, түүнд тавигдах шаардлагыг тодорхойлно. Түүнчлэн

геоплатформыг бүрдүүлэгч, хэрэглэгч талуудын хоорондын уялдаа холбоо, орон зайн өгөгдөл, мэдээлэлд суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг дэмжих зохицуулалтын талаар тусгана.

Төрийн байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд бүрдүүлсэн орон зайн өгөгдлийг геоплатформд төвлөрүүлэх, тэдгээрийн үнэн зөв байдлыг хариуцах асуудлыг тусгана.

Дөрөвдүгээр бүлэгт орон зайн өгөгдлийн дэд бүтцийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах эрх бүхий байгууллага, хувийн хэвшлийн оролцоо, тэдгээрийн эрх, үүргийн талаар тусгана. Мөн өгөгдлийн сангуудын нэгдмэл байдлыг хангах, түүнийг хэрэгжүүлэх хүний нөөцийг бүрдүүлэх талаар болон орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг дэмжихтэй холбоотой зохицуулалтыг тусгана.

Мөн орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааны санхүүжилтийн талаар болон хяналт хэрэгжүүлэх нөхцөлийн талаар тусгана.

Тавдугаар бүлэгт хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

Хуулийн төсөл батлагдсанаар эдийн засаг, нийгмийн дараах үр дагавар бий болно гэж үзэж байна.

Орон зайн өгөгдөл, мэдээллийн бүрдүүлэлт, боловсруулалт, хадгалалт, хамгаалалт, хэрэглээ, түгээлтийн нэгдсэн тогтолцоо бүрдэж, байрлалд суурилсан орон зайн бүх төрлийн агуулга бүхий өгөгдөл, мэдээллийг нэг газрын зурагт нэгтгэж, төрийн байгууллага, иргэд олон нийт бизнесийн зорилгоор ашиглах боломж бүрдэнэ. Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч, хэрэглэгчийн харилцан мэдээлэл солилцох нөхцөлийг тодорхой зохицуулснаар улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах чиглэлээр төсөл, хөтөлбөр, арга хэмжээг орон зай, байрлалын хувьд бодитой, үндэслэлтэй төлөвлөх, барьж байгуулах таатай нөхцөл бүрдэнэ.

Орон зайн суурь өгөгдөл, мэдээллийг бодитой, үнэн зөв бүрдүүлэх, ашиглах, хэрэглэх, түгээх, харилцан солилцох боломж нэмэгдэж, тэдгээрт зарцуулагдах зардлыг хэмнэх нөхцөл бүрдэж, орон зайн өгөгдөл, мэдээллийг олон нийт нээлттэй, хүртээмжтэй хэрэглэх, ашиглах эрх зүйн орчин бүрдэнэ.

Орон зайн өгөгдлийн дэд бүтэц нь төрийн үйлчилгээний нэг хэсэг тул цахим засаглалыг байрлалд суурилсан төрөл бүрийн өгөгдөл, мэдээллээр хангаад зогсохгүй бүх салбарын орон зайн өгөгдөл, мэдээллийг нэг цэгээр дамжуулан төрийн үйлчилгээг иргэдэд түргэн, шуурхай хүргэх боломж нэмэгдэнэ.

Хот байгуулалт, дэд бүтцийн төлөвлөлт, гамшиг, гамшгийн онцгой байдал үүссэн үед нэгдсэн нэг эх үүсвэрээс орон зайн суурь өгөгдөл, мэдээллийг авах, солилцох нөхцөл бүрдэж, статистикийн болон бусад бүх төрлийн мэдээлэлтэй

давхцуулан тодорхой зорилго бүхий нэмүү өртөг шингээсэн мэдээлэл гарган авах, ашиг олох, бизнесийн орчныг дэмжих нөхцөл бүрдэнэ.

Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тогтолцоог бүрдүүлэхэд орчин үеийн дэвшилтэт техник, технологийг ашиглах, цахим программ хангамжийг хөгжүүлэх, хүний нөөцийн чадавхыг сайжруулахад чиглэсэн тодорхой хэмжээний төсөв шаардагдана.

Дөрөв.Хуулийн төсөл нь бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар:

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай болон Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Хаягжуулалтын тухай, Геодези, зураг зүйн тухай, Төрийн болон албаны нууцын тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

-----oOo-----